



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 32


Улаанбаатар хот

Даатгалын байгууллага, даатгалын мэргэжлийн оролцогчид аудит хийх эрх олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 33.2.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20.2.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан "Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам"-ын 2.1 дэхь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. Тогтоолын 1 дүгээр хавсралтад дурдсан 5 аудитын компанид даатгалын байгууллага, даатгалын мэргэжлийн оролцогчид аудит хийх эрхийг 3 жилийн хугацаагаар олгосугай.
2. Тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан 8 аудитын компанийн даатгалын байгууллага, даатгалын мэргэжлийн оролцогчид аудит хийх эрхийг 3 жилийн хугацаагаар сунгасугай.
3. Компанийн өөрчлөлт, аудиторчуудын шилжилт хөдөлгөөний талаар тухай бүр Хороонд мэдээлж байхыг эрх авсан аудитын компаниудын удирдлагад үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Х.Бум-Эрдэнэ)-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

090052

Санхүүгийн зохицуулах хорооны
2013 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн
32 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

Шинээр эрх авах аудитын компанийн нэрс

УХА0410 5043239

№	Аудитын компанийн нэрс	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар	Тусгай зөвшөөрлийн дугаар
1	“Конфиденсе-Аудит”ХХК	2883562	9018001022	050-2005
2	“Бэст фортуна-Аудит”ХХК	5345847	9018001054	094-2011
3	“Баян ташаагийн эх-Аудит”ХХК	3125432	9018001058	098-2011
4	“БДО-Аудит”ХХК	2546442	9018001010	009-1997
5	“Ворлд гал-Аудит”ХХК	5547202	9018001068	110-2012

Санхүүгийн зохицуулах хорооны
2013 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн
32 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

Эрх сунгах аудитын компанийн нэрс

УХА0410 5043230

№	Аудитын компанийн нэрс	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн дугаар	Тусгай зөвшөөрлийн дугаар	Тайлбар
1	“Акпар-Аудит” ХХК	5229979	9018001021	065-2008	Гэрчилгээнд сунгалт хийх
2	“Ди Эй Би Жи-Аудит” ХХК	2648768	9018001032	028-2001	Гэрчилгээг шинэчилж сунгалт хийх
3	“Мэдээлэл-Аудит” ХХК	2703939	9018001023	035-2002	Гэрчилгээг шинэчилж сунгалт хийх
4	“Координат-Аудит” ХХК	2565617	9018001031	015-1998	Гэрчилгээнд сунгалт хийх
5	“Пантермидланд-Аудит” ХХК	5103614	9019021058	058-2007	Гэрчилгээнд сунгалт хийх
6	“Интер-Аудит” ХХК	2712113	9018001012	026-2001	Гэрчилгээг шинэчилж сунгалт хийх
7	“Би Энд Си-Аудит” ХХК	2549654	9018001001	021-1999	Гэрчилгээг шинэчилж сунгалт хийх
8	“Эс Жи Эм Ди-Аудит” ХХК	5050286	9018001042	078-2009	Гэрчилгээнд сунгалт хийх
